



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/23

Өвт

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч  
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай" А/33 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үүртийн тохойн постын хяналтын цэгийн үйл ажиллагааг сайжруулан, голомтот бүс нутгаас ирж байгаа иргэдэд эрүүл мэндийн хяналт хийх, бүртгэх, шаардлагатай үед түргэвчилсэн оношлуур хийх түр цэгийг Эрүүл мэндийн төвд ажиллуулах, тусгай зөвшөөрлийн QR кодыг шалган нэвтрүүлж ажиллахыг сумын Онцгой комисс (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

2. Голомтот бүсээс ирсэн иргэдийг гэрийн хязгаарлалтад 14 хоног байх хугацаанд халдвар, хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавих ажлыг эрчимжүүлж, хамтран ажиллахыг сумын Онцгой комисс Н.Бат-Эрдэнэ), Эрүүл мэндийн төвийн дарга (О.Отгонболд), нийгмийн ажилтан (Г.Ганчимэд), багийн Засаг дарга (Т.Жамъянжав, Д.Даваацэрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Л.Балжинням) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон хугацааг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасугай.

4. Захирамжийн дээрх заалтыг зөрчсөн тохиолдолд архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад (Д.Энх-Амгалан), Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (П.Аюушжав) нарт үүрэг болгосугай.

5. Халдвар хамгааллын дэглэм зөрчиж, маскгүй, хүн хоорондын зай барихгүй үйл ажиллагаа явуулсан худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг зогсоож, хариуцлага тооцохыг сумын Онцгой комисс (Н.Бат-Эрдэнэ), Цагдаагийн тасаг, Цагдаагийн ахмад (Д.Энх-Амгалан), Эрүүл мэндийн төвийн дарга (О.Отгонболд) нарт үүрэг болгосугай.

6. Сумын Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ОРЛОГЧ

Л.БАТЧУЛУУН



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

05#010045